



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/420

Чингис хот

Боловсрол, соёл, урлагийн газрын нэршлийг  
өөрчилж, бүтэц шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.16 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 09, 2021 оны 168 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн Боловсролын газрын үлгэрчилсэн журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт соёлын хэлтэс байгуулагдаж байгаатай холбогдуулан аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын нэршлийг Боловсролын газар болгон өөрчилж, бүтцийг хавсралтад дурьдсанаар шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан бүтцийн дагуу албан хаагчдыг томилж, байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн мөрдөж ажиллахыг Боловсролын газар (С.Мөнхцэцэг)-т даалгасугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231012017